

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
2025.11.13

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/ ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1.	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	80	80- аас дээш хувь	2025 оны байдлаар 3900 иргэнд тоон гарын үсэг олголоо. Тоон гарын үсгийг 588 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 3312 иргэний гар утсанд gsign аппликейшн суулган олгосон байна. Нийт 26826 иргэнд тоон гарын үсэг олгож 83,7 хувьтай байна. УБЕГазрын ИУБГазраас ирсэн 3/10321 тоот чиглэлийн дагуу тоон гарын үсгийг олгохдоо иргэний үнэмлэх, гарын хурууны хээг төхөөрөмжөөр уншуулан тоон гарын үсгийг олгож байна. Эрүүл мэндийн шалтгааны улмаас хурууны хээ уншигдахгүй байгаа 95 иргэнд тоон гарын үсгийг регистрийн дугаараар олгосон. Тоон гарын үсгийн мэдээг сар бүр аймгийн ЗДТГазрын хууль эрх зүйн хэлтэст 10 удаа хүргүүлсэн байна.	100
1.2.	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Үйл ажиллагаанд дүнд шинжилгээ хийсэн тоо	2	2	Улсын бүртгэлийн цахимаар үзүүлж байгаа үйлчилгээ, улсын бүртгэгчдийн бүртгэсэн бүртгэлийн тоо, бүртгэгчдийн ажлын ачаалал зэрэгт өгөгдлийн шинжилгээг хийлээ. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн статистик бүртгэлийн тоон мэдээний үзүүлэлтээс 13 сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн ИГББүртгэлийн 1007, иргэний үнэмлэхийн 1793, шилжилт	100

					хөдөлгөөний 1754, иргэдэд олгосон лавлагаа 2304 нийт 6858 бүртгэлд харьцуулалт хийж үзэхэд нэг бүртгэгч ажлын 1 өдөрт дунджаар 17 бүртгэл хийж байна. Бүртгэгч тус бүрээр үзэхэд Сайнцагаан сумын улсын бүртгэгч 3950 буюу нийт бүртгэлийн 57,6 хувийг эзэлж байгаа бол хамгийн бага бүртгэлийг Өлзийт сумын улсын бүртгэгч 70 бүртгэл буюу нийт бүртгэлийн 1 хувийг эзэлж байна. Улсын бүртгэлийн үйлчилгээний киоск машин болон төрийн үйлчилгээний хурдан системээс авсан үйлчилгээний тоог харуулбал төрийн үйлчилгээний хурдан системээс иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6935 бүртгэлийн лавлагаа мэдээлэл, киоск машинаас 3328 лавлагаа нийт 10263 бүртгэлийн үйлчилгээг цахимаас гарсан байна. Бүртгэлийн үйлчилгээний төрлөөр авч үзэхэд цахим үнэмлэхийн лавлагаа 5950, хаягийн лавлагаа 2730, төрсний бүртгэлийн лавлагаа 920, гэрлэлтийн лавлагаа 458 иргэний үнэмлэхийн захиалга 85 бусад төрлийн лавлагаа 120 байна. Цахимаас авч байгаа үйлчилгээний дийлэнх буюу 98 хувь нь лавлагаа эзэлж байгаа бөгөөд цахимаар улсын бүртгэл хийлгэж байгаа тоо байхгүй байгаа нь мэдээлэл хангалтгүй, иргэдийн цахим хэрэглээ, интернэт орчинд ажиллах чадвар дутмаг байна гэж харагдаж байна. Мөн төрийн үйлчилгээний хурдан системээс авсан үйлчилгээний тоо бүртгэлийн киоск машинаас авсан тооноос 1 дахин их байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа аймгийн төвийн 2, сумын 4 бүртгэгчийн 2025.01.01-2025.06.30-өдрүүдэд бүртгэсэн бүртгэлд өгөгдлийн шинжилгээ хийсэн. Тус хугацаанд нийт 1842 бүртгэл хүлээн авч боловсруулсан бөгөөд аймгийн төвийн 2 бүртгэгч тус бүр 757, 784, сумын бүртгэгчид 3,8,13,17 буюу 1 бүртгэгчийн 1 сард бүртгэсэн бүртгэлийн тоо аймгийн төвд 126-131, өдөрт бүртгэсэн	
--	--	--	--	--	---	--

						бүртгэлийн тоо 6.0-6.2, сумын бүртгэгчийн сарын дундаж 1.0-2.8 байна.	
1.3.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	100	100	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 01 өдөр хүртэлх хугацаанд 139 мэдээллийг 100 хувь байршуулсан. Үүнээс мэдээлээгүй мэдээлэл 0, хугацаа хоцорсон төлөвтэй мэдээлэл 0, хугацаандаа байршуулсан 139 мэдээлэлтэй, 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.	100
		-	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	171		2025 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 11-р сарын 1-ны өдрийн байдлаар 139 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг бүрэн байршуулсан.	100
1.4.	Төрийн болон хууль хяналтын байгууллагад мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох	-	лавлагаа, мэдээллийн тоо	200	110	шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүсэлтээр 91, Дундговь аймаг дахь сум дундын шүүхэд 115, прокурорын хүсэлтээр 69, цагдаагийн байгууллагын хүсэлтээр 28, Авлигатай тэмцэх газар 30 лавлагаа олгожээ. Хууль хяналтын байгууллагад олгосон лавлагааг өнгөрсөн онтой харьцуулахад 50 хувиар бага байна. Мөн авч байгаа лавлагааны дийлэнх буюу 75,9 хувийг иргэний оршин суугаа газрын хаягийн лавлагаа эзэлж байна. Хуулийн байгууллагын албан тоотын дагуу 292 иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө бүртгэлтэй эсэх, эд хөрөнгийн лавлагааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /eprs.mn/-aac гарган хүргүүлсэн.	100
1.5	Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх		Байнгын хяналтад авч хэрэгжүүлсэн тогтоол шийдвэрийн тоо	6	6	Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн 2025 оны тайлант хугацаанд 3499 иргэнд тоон гарын үсэг олголоо. Тоон гарын үсгийг 573 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 2926 иргэний гар утсанд gsign аппликейшн суулган олгосон байна. Нийт 26734 иргэнд	100

					тоон гарын үсэг олгож 82,9 хувьтай байна. - Аймаг нийслэл сум дүүргийн ИТХурлын нөхөн сонгууль тус аймгийн Адаацаг сумын 4-р баг Сүм, Өлзийт сумын 4-р баг Дэрт -1, Сайхановоо сумын 2-р баг Мааньт хэсэгт тус тус явагдана. Нөхөн сонгуулийн ажлын хүрээнд ИУБГазраас өгсөн нөхөн сонгууль зарласан тухай дээрх сумдын ИТХурлын тогтоол шийдвэрийг ИУБГазарт хүргүүлсэн мэдээллийг сонгуулийн программд шивж оруулсан тухай, сонгогчдын нэрийн жагсаалтад төлөв оноосон байдалд тулгалт хийсэн тухай, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэсэн тухай, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон тухай зэрэг 6 үүрэг даалгаврыг бүртгэлд авч хэрэгжилтийг ханган ажиллаж тайланг илтгэх хуудсаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. - “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, чирэгдэл үүсгэхгүй байх, иргэдийг цахим орчинд төрийн үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулахад анхан шатанд шийдвэрлэж болох зарим асуудлыг хамтын ажиллагаан дээр шийдвэрлэх, холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах саналыг цахим хөгжлийн хэлтэст хүргүүллээ. 20 минутын Дундговь аймаг бодлогыг хэрэгжүүлэн бүртгэлийн үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллаж байна. - Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай үийдвэрийн дагуу 2025 онд албан хэрэг хөтлөлтийг бүрэн хөрвүүлж тус хэлтсийн 8 албан хаагч цахим бичвэрт суралцан хэрэгжүүлж ажиллаж байна. - Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх	
--	--	--	--	--	--	--

						шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгосны дагуу ERP системийг бүрэн нэвтрүүлсэн. - Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус хэлтсийн албан хаагчид 3 төрлийн 35 модыг шинээр тарьж арчиллаа.	
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөт болон, гүйцэтгэлийн хяналтыг зохион байгуулах, арга зүйгээр хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Хяналтын улсын байцаагч нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 26 арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүлж ажиллалаа. Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт 8, гэнэтийн болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт 2, Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт 1 байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2111 бүртгэлд хийснээс иргэний улсын бүртгэлийн 999, ЭХЭУБ-ын 957, хуулийн этгээдийн 140, архивын чиглэлээр 15 байна. Үүнээс иргэний улсын бүртгэлийн 50, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 92, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 16, архивын үйл ажиллагааны 2 алдаа зөрчил илэрсэн байна. Илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засаж, дүгнэлтээр засах алдаа зөрчлийг дүгнэлтээр засаж ажиллалаа. Хяналтын улсын байцаагчийн 32 дүгнэлт, 1 мэдэгдэл үйлдэж хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд цахимжууллаа. Үүнд: иргэний улсын бүртгэлийн 7, хуулийн этгээдийн 3, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 22 тус тус дүгнэлт байна. 2025 онд хяналтын улсын байцаагчид төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn порталаар нийт 24 албан бичиг, 6 өргөдөл ирүүлсэн бөгөөд	100

					хуулийн хугацаанд боловсруулж шийдвэрлэсэн. Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт 2025 оны 03 дугаар сард төрсний бүртгэл-262, гэрлэсний бүртгэл-53, 2025 оны 04 дүгээр сард шилжилт хөдөлгөөний бүртгэл-386 2025 оны 05 дугаар сард нас барсны-83, ОНӨ бүртгэл-10, эцэг тогтоолын бүртгэл-5 2025 оны 06 дугаар сард гэрлэлт цуцлалт-26, үрчлэлт-8 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийж улсын бүртгэгч нарт нийтлэг гарч буй алдаа зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн даргад танилцуулж, тасгийн даргатай хамтран 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр сумдын бүртгэгч нарт цахим сургалт зохион байгууллаа. УБЕГазрын 2025 оны 06 сарын 25 -ны өдрийн 1/8305 тоот зөвлөмжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн тасгаас улсын бүртгэгчдэд чиглэл өгөх сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар гэрлэлт дуусгавар болсны бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлаар улсын ахлах бүртгэгч Б. Сайхантуяа, "Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин төгөлдөр хугацааг анхаарах асуудлаар хяналтын улсын байцаагч Д. Нямсүрэн нар мэдээлэл өглөө. ЭХЭУБ-ийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт 2025 оны 1,2,3, 4 дүгээр сард төрөөс хувьчилсан газрын анхны бүртгэл 298, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 123, шинээр баригдсан орон сууцны бүртгэл 145 2025 оны 5,6 дугаар сард худалдах, худалдан	
--	--	--	--	--	--	--

					авах гэрээ 103, бэлэглэх гэрээ 86, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх-78 2025 оны 8,9,10 сард барьцаат зээлийн гэрээ дуусгавар болох, барьцаат зээлийн гэрээ-124 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийж илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засч, дүгнэлтээр засах алдаа зөрчлийг дүгнэлтээр засч ажиллалаа. Мөн шинээр барьж ашиглалтад оруулж буй орон сууцны 5 бүртгэлд анхан шатны нотлох баримтын бүрдүүлэлтэд хяналт хийж, зөвлөн тусалж бүрдүүлбэрийг бүрэн бүрдүүлж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд цахимжуулж Ж дугаар олгууллаа. 2025.09.04-ны өдөр Говь-Угтаал сумын Хараат хэмээх газарт орших “Шанжин орд” ХХК-ны Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан 10 үл хөдлөх эд хөрөнгийг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Л.Мөнхсарнайтай газар дээр нь очиж объектын үзлэг хийж, зөвлөгөө өглөө. Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн бүртгэгч, архивч нар Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн хяналтын тооллогыг 2025 оны 4 дүгээр сарын 7-14-ны өдрүүдэд хийсэн бөгөөд илтгэх хуудсаар хяналтын улсын байцаагчид тайланг ирүүлсэн. Тооллогод 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн байдлаар архивт байршуулсан газар өмчлөх эрхийн 12711, үл хөдлөх эд хөрөнгийн 4901 нийт 17612 хувийн хэргийг нэг бүрчлэн мэдүүлэг, дугаарын дарааллыг шалгаж буцаан байрлуулж, өөр улсын бүртгэлийн хувийн хэрэгт байршуулсан 41 бүртгэлийг улсын бүртгэлийн дугаар бүхий хувийн хэрэгт	
--	--	--	--	--	---	--

						байршуулж, тусгаарласан 48 бүртгэлийг устгасан байна. Тайланд ирүүлсэн алдаа зөрчил, дутуу нотлох баримт, дутсан хувийн хэргийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS системд шалгаж 6 бүртгэлийг дүгнэлтээр засварлалаа. Хуулийн этгээдийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт 2025 оны 1-10 сард шинээр байгуулагдсан хоршоо 20, ХХК-20, төрийн бус байгууллага 6, нөхөрлөл 4, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулсан ХХК-30, хоршоо 30, боловсрол соёл сургалтын байгууллага 20, хуулийн этгээдийн лавлагаа олголт 10 тус тус хяналт шалгалт хийж илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засаж, засаж ажиллалаа.	
2.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск)-ийн тоог нэмэгдүүлэх	-	Аймгийн хэмжээнд улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /Киоск/-ны нэмэгдүүлсэн тоо	2	2	Баянжаргалан, Говь Угтаал, Өлзийт сумдад орон нутгийн санхүүжилтээр КИОСК суурилуулан 24/7 үйлчилгээг нэвтрүүллээ. Үүнд 73,0 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
2.3.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх 4жи төхөөрөмж ашиглах	-	Улсын бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээний тоо	8	2	Сүлжээний зөөврийн 4g төхөөрөмж ашиглан ШШГТ, Аймгийн 15 суманд Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/407 тоот захирамжийн нэгдүгээр хавсралтад дурдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын сумдын иргэдтэй хийх “Хөдөөгийн сэргэлт-шинэ Дундговь” уулзалтын үеэр нийт 15 удаа ашиглан бүртгэлийн үйлчилгээг сурталчлан ажиллалаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2 удаа, Сайнцагаан сумын 7-р багт, Баянжаргалан, Говь-угтаал, Цагаандэлгэр, Өндөршил,	100

						Дэрэн, Луус, Дэлгэрхангай зэрэг сумдын иргэдтэй хийсэн уулзалт өдөрлөгт 8 удаа, Сайнцагаан сумын 6 дугаар багийн өндөр настанд шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 1 удаа, Дэрэн, Баянжаргалан, Дэлгэрцогт сумдын улсын бүртгэгчид тус бүр 1 удаа, Хуульчдын “Поро боно-2025” өдөрлөгт” 1 удаа нийт 15 удаа иргэний бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр хөдөлгөөнт хэлбэрээр хүргэсэн бөгөөд нийт 250 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Аймгийн Засаг дарга түүний тамгын газраас “Асуудал шийдэл” төрийн үйлчилгээг үзүүлэх, иргэдтэй хийх уулзалтыг 2025 оны 9 сарын 4-5 , 10 сарын 6-9 ны өдрүүдэд аймгийн баруун зүүн сумдад зохион байгууллаа. Тус арга хэмжээнд улсын бүртгэлийн хэлтсээс зөөврийн төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээг 230 иргэнд үзүүллээ. Өлзийт суманд 2025 оны 11 сарын 4-ны өдөр зохион байгуулсан малчны өдөрлөгт оролцон 25 иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. 11 дүгээр сарын 6-ны өдөр аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажлын байр, “Мандал худалдааны төв”-ийн 1 давхарт тус бүр 1 удаа үйлчилгээ үзүүллээ.	
2.4.	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөн явуулах	-	Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтөлсөн тоо	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	Тайлант хугацаанд 14688 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд 549 хүүхэд, гэрлэлтийн бүртгэл 103, үрчлэлт 14, гэрлэлт цуцлалтын бүртгэл 43, эцэг тогтоолтын бүртгэл 24 , ОНӨ бүртгэл 31, нас барсны бүртгэлд 243 нийт иргэний гэр бүлийн бүртгэлийн 1007 бүртгэл, 1754 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд, үндэсний энгийн гадаад паспорт 2069, иргэний үнэмлэх 1793, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 462 нийт 7085 бүртгэл хөтлөн иргэний бүртгэлийн санд мэдээллийг баталгаажуулсан байна.	100

						Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас 549 хүүхдийн регистрийн дугаарыг унагаж төрсний бүртгэлд бүртгэсэн бөгөөд 280 эрэгтэй, 269 эмэгтэй хүүхэд төрсний бүртгэлд бүртгэгдсэн байна. Нийт төрсөн хүүхдийн 66,4 хувь буюу 365 хүүхэд Сайнцагаан суманд төрсний бүртгэлд бүртгэгдсэн байна. Эрүүл мэндийн яамны мэдээллийн санд регистрийн дугаар хүйс зөрүүлж бүртгэсэн нэг иргэний бүртгэлийг аймгийн төрөх тасагт хүргүүлэн ЭМДГазрын мэдээллийн сангаас устгуулж дахин регистрийн дугаараар төрөлтийн бүртгэлд хамрууллаа. Төрсөн эхчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-19 насны 28, 20-24 насны 120, 25-29 насны 155, 30-34 насны 135, 35-39 насны 92, 40-44 насны 18 эмэгтэй төрсөн байна. Батлуулсан гэр бүлтэй 240 эмэгтэй, батлуулаагүй гэр бүлтэй 131 эмэгтэй төрж, бүрэн дунд боловсролтой 223 дээд боловсролтой 205 эх төрсөн нь нийт төрсөн эхчүүдийн 77,9 хувь байна.	
2.5.		-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хууль тогтоомж, журмын дагуу эрхлэн хөтөлсөн тоо	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	2025 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 3240 мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнд: төрөөс хувьчилсан газрын анхны бүртгэл 502, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 285, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл 145, худалдах худалдан авах гэрээ 474, бэлэглэх гэрээ 117, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 78, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 2, бусад эрх шилжүүлэх бүртгэл 5, барьцааны гэрээний бүртгэл 916, барьцааны гэрээ дуусгавар болгох 645, түрээсийн гэрээ 4, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох 21, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 59, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 3, эд хөрөнгийн хэмжээ үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 45, лавлагаа хуулбар 56, хувийн хэрэг хаах 11 бүртгэл тус тус бүртгэсэн байна. Үйлчилгээний хураамж 91.2 сая.төгрөг, улсын	100

						тэмдэгтийн хураамж 3.5 сая.төгрөг, ҮХЭХҮЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 329.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. /2024.12.26-2025.11.10-ны байдлаар/	
2.6.		-	Хуулийн этгээдийн бүртгэлийг хууль тогтоомж, журмын дагуу эрхлэн хөтөлсөн тоо	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан: ххк 88, Хоршоо 39, ХЗХ 8, Улсын төсөв үйлдвэрийн газар 10, төрийн байгууллага 6, ТББ 9, ҮЭХ 2, Боловсрол соёлын сургалтын байгууллага 43. ОНӨААҮГ 4 бүртгэсэн,ТӨААТҮг 1, Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон 64, Салбар төлөөлөгчийн газар бүртгэсэн 6, нийт -220 хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон 64, 2.Шинээр 149 хуулийн этгээд байгуулсан. Үүнээс: ххк 61, хоршоо 57,Төрийн бус байгууллага 11 , ОНӨААТҮГ 1, ҮЭБ 1, нөхөрлөл 7 бүртгэгдсэн байна. Дахин гэрчилгээ олгосон 72 , ,шилжилт хөдөлгөөн хийсэн 6 , нийт 433 бүртгэл хийж архивд 2115 хувийн хэрэг байршиж байна “Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам”-д зааснаар Хяналтын дугаар олгосон шинээр 150 , дахин олгосон 62, хураан авсан 76 тамга, тэмдэг архивд шилжүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн орлогод:19193600 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр боловсролын сургалтын байгууллага сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжил болон техникийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын 43 сургууль, цэцэрлэгийн хэлбэрийг өөрчлөн хуулийн хэрэгжилтийг хангасан. Хуулийн этгээдийн оноосон нэрийг е-	100

						business.mn хүлээн авч татгалзсан 1407 , зөвшөөрсөн 242 , баталсан 25 , цуцалсан 157 нийт 1407 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.	
2.7.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг сумдад бүртгэх боломжийг нэмэгдүүлэх	-	Хуулийн этгээдийн бүртгэлийн эрхтэй сумдын бүртгэгчийн тоо	5	2	15 сумаас 5 бүртгэгч хуулийн этгээдийн бүртгэлийн эрхтэй ба Эрхзүйч мэргэжил эзэмшсэн Луус сумын бүртгэгч, Өндөршил суманд шинээр томилогдсон бүртгэгч нарын судалгааг УБЕГ-т хүргүүлэн сургалтад хамруулж байна.	100
2.8	Иргэдийн Санал өргөдөл Гомдлын шийдвэрлэлтийг хууль тогтоомж, журмын дагуу барагдуулах	-	Санал өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	2025 онд иргэдээс 15 өргөдөл хүсэлт ирсэн ба өргөдөл хүсэлтийн барагдуулалт 100% хугацаа хоцроож шийдвэрлэсэн өргөдөл байхгүй байна. Иргэд олон нийттэй харилцах төв буюу 1111 тусгай дугаарт 1 талархал ирсэн байна.	100
			Шийдвэрлэлтийн хугацаа	7	7	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног байна.	100

ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

3.1.	Үнэт цаасны зарцуулалтад хяналт тавьж бүртгэгчийн буруутай үйлдлээс хүчингүй болголтыг бууруулах.	-	Хүчингүй болгосон үнэт цаасны тоо	60	60	Үнэт цаас зарцуулалтын хяналт, шалгалт Улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг хүчингүй гэрчилгээ 2 гаргасан бусад зөрчил илрээгүй. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс алдаа илрээгүй. Иргэний улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтын тайлан, иргэний улсын бүртгэлийн статистик мэдээ зөрүүтэй, 11 сумын улсын бүртгэгчдийн үнэт цаасны тайлагналтад хяналт шалгалт хийхэд 3 сум алдаагүй, 9 сумын улсын бүртгэгчдийн тайлан мэдээ зөрүүтэй алдаа илэрсэн тул албан мэдэгдэл өгч илтгэх хуудсыг хүлээн авлаа. 2025 оны 11 сарын 1-ний байдлаар 69 Үнэт цаас хүчингүй болсноос 54 нь Улсын бүртгэгчийн алдаанаас, 15 нь техникийн алдаанаас хүчингүй болсон.	100
3.2.	Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь	100	100	2024 оны жилийн санхүүгийн тайлангийн аудитаар Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Түүвэрт” хамруулсан тул санал дүгнэлт байхгүй.	100
3.3.	Улсын бүртгэлийн байгууллагын компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулах	ОНТөс өв, төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэр	Техник, тоног төхөөрөмжийн шинэчилсэн тоо	6	6	УБЕГ-аас шинэ компьютер-5ш, 3 үйлдэлт принтер-5ш, А,В конвертер-1ш, dell notebook-3ш, canon сканнер-1ш ОНТөсөвөөс Өлзийт, Говь-Угтаал суманд цахим машин /Киоск/-2ш, Өлзийт, Баянжаргалан, Сайнцагаан, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдад шинэ нөүтбүүк-5ш тоног төхөөрөмжийг шинээр хүлээн авлаа. Нийт 17 ш төхөөрөмж шинээр нийлүүлж тоног төхөөрөмжийн хангалт 100 хувь болж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100
3.4.	УБЕГазраас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	100	100	ХЗДХЯ дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 3 сарын 17 өдрийн үүрэг, УБЕГ-ын даргын зөвлөлийн хурлаас өгсөн 2 удаагийн үүрэг даалгаврын биелэлт болон албан бичгээр ирүүлсэн	100

						хугацаатай албан даалгаврыг хугацаанд нь хүргүүлж ажилласан. УБЕГазраас 2025 онд 8 удаагийн үүрэг даалгавар ирүүлснийг тухай бүр хэрэгжүүлэн илтгэх хуудас, тайланг хүргүүлж ажилласан.	
3.5	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сйжруулах	Бусад эх үүсвэр	Хэлтсийн архивын тавиурын нэмэгдүүлсэн тоо	2	0	Архивын тавиур суулгаснаар архивын хадгалалт хамгаалалт эмх цэгцтэй болж ажлын байрны зай талбай нэмэгдсэн. Архивын тавиурыг нэмэгдүүлснээр эд хөрөнгийн архивын хавтаслалтыг шинэчлэн хийж ажиллаж байна. Бүртгэлийн архивын 316 баримтыг цэгцэлж хавтаслан хаягжуулж, хадгаламжийн нэгжийн байрлалын заагуурыг 100 хувь шинэчилсэн. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж аймгийн ЗДТГазраас урьчилсан шалгалт ирэхэд хангалттай сайн үнэлэгдсэн.	100
ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
4.1.	Аймгийн ИТХурал, Засаг дарга, ЗДТГазартай хамтран ажиллах	Тухай бүр урсгал зардал , хөрөнгө бусад эх үүсвэрээр	Аймгийн ИТХ, ЗДТГазартай хамтран ажилласан арга хэмжээний тоо	2	2	Аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 1,2,3-р улиралд дүгнүүлэн хангалттай сайн үнэлгээ авч орон нутгийн нэмэгдлийг авсан байна. Хөдөөгийн сэргэлт шинэ Дундговь хөтөлбөрийн хүрээнд хөдөөгийн 15 сумдын иргэдтэй хийх Засаг даргын уулзалтад бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажлын хэсэгт орж ажиллан 3 албан хаагчийн 30 хоногийн томилолт унаа хоолны зардлыг бүрэн шийдвэрлүүллээ. Албан хаагчдын сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд 5,0 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг аймгийн Засаг даргын нөөц сангаас шийдвэрлүүллээ. Аймгийн иргэдийн хурлаас Сайнцагаан сумын Наран багийн иргэдтэй зохион байгуулсан уулзалтад улсын бүртгэлийн үйлчилгээний мэдээллийг 63 иргэнд хүргэсэн. Хэлтсийн үйлчилгээний танхимд урсгал засварын ажлыг хийлгэж ажиллах орчныг сайжрууллаа. Сумдын улсын бүртгэгч нарыг эрүүл	100

						мэндийн багц үзлэгт сумдын ЗДТГазрын санхүүжилтээр нагррийн мэргэжлийн 3-р шатны эмнэлэгт үзүүлж 3,8 сая төгрөгийн дэмжлэгийг авсан байна.	
		Тухай бүр урсгал зардал , хөрөнгө бусад эх үүсвэрээр	15 сумдын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазартай хамтран ажилласан үйл ажиллагааны тоо	5	5	ОНТөсөвөөс 3 суманд цахим машин /Киоск/-2ш, 5 сумдад шинэ нөүтбүүк-5ш тоног төхөөрөмжийг шинээр хүлээн авлаа. Нийт 85,0 сая төгрөгийн төхөөрөмж нийлүүлсэн байна.	100
4.2	Бусад төрийн болон ТББайгууллагатай хуулийн хүрээнд хамтран ажиллах	Бусад эх үүсвэр	Хамтран ажилласан арга хэмжээний тоо	2	2	ШШГүйцэтгэх байгууллагын хүсэлтээр тус газар хоригдож байгаа Өвөрхангай аймгийн нэг иргэнийг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, мөн нэг иргэний гэрлэлтийн бүртгэлийг зөөврийн төхөөрөмжөөр бүртгэлээ. Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгт хамтран оролцож 39 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. 11 дүгээр сарын 6-ны өдөр зөөврийн 4жи төхөөрөмжөөр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажлын байр, “Мандал худалдааны төв”-ийн 1 давхарт байрлан 43 хувиараа хөдөлмөр эрхлэгч болон иргэдэд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн, qr кодтой цахим гарын авлагыг 146 иргэнд	100

						тараан, мэдээлэл хүргэлээ.	
4.3	Хэлтсийн үйл ажиллагааны 2025 оны эрсдлийг тодорхойлох	-	Эрсдэл тодорхойлж боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	УБЕГазраас 6-р сарын 5 өдөр нэгдсэн санал албан ёсоор авч хариуг хүргүүлэн ажиллалаа. Хэлтсийн үйл ажиллагааны 2025 оны эрсдэлийг тодорхойлон 2 ангилалд хуваан 6 төрлийн эрсдэлийг тодорхойлон төлөвлөгөөний санал хүргүүлсэн. Дээрх эрсдэлүүдийг дэд төлөвлөгөө болгон хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилт 100 хувь.	100
ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
5.1.	2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	80	100	УБЕГазраас ирүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд тус хэлтэс 4 зорилтын хүрээнд 9 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан баталж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. Үйлчлүүлэгч иргэд, албан хаагдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөлөөллийг арга хэмжээнүүдийг ажлын байранд хийж үйл ажиллагаандаа тэднийг татан оролцуулж ажиллалаа. 2025 онд ашиг сонирхлын зөрчил илрээгүй, хариуцлага тооцогдсон албан хаагч байхгүй, гомдол санал бүртгэгдээгүй болно.	100
5.2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг цахим орчинд явуулах	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны	8	2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах боломж, нөхцөлийг хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч, "Авлигын эсрэг нэгдье" контент бэлтгэж иргэдэд хүргэсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, шторк, мэдээллийг АТГазрын вэб хуудас болон УБЕГазрын вэб хуудсаас 8 удаагийн мэдээлэл татаж Бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудас, Дундговь аймаг дахь бүртгэлийн хэлтэс олон нийтийн фэйс хуудас, Dundgovi.burtgel.gov.mn вэб хуудас, бүртгэлийн	100

			цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо			үйлчилгээний танхимд байрладаг “Цахим мэдээллийн лед дэлгэц”-ээр, мөн нийт албан хаагчид хувийн facebook хуудсандаа хуваалцаж олон нийтэд сурталчилсан нийт 2 удаа иргэд, олон нийтэд хүргэх сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. Нийт 1050 иргэн хандсан байна. Ёс зүйгээр үлгэрлэе аяны хүрээнд хамт олны дунд 3 удаагмйн үйл ажиллагаа зохион байгуулж цахим орчинд контент болгон нийтэд түгээсэн.	
ЗОРИЛТ 6. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
7.1.	Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Улсын бүртгэлийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 2025 оны сургалтын төлөвлөгөөг нийт албан хаагчдаас ирүүлсэн саналыг тусган 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс тасарсан болон дутуу хэрэгжсэн заалт байхгүй. Төлөвлөгөөний хэрэгжилтийг УБЕГазарт хугацаанд нь гарган хүргүүллээ. Цаашид танхимын 1 удаагийн сургалтын зардлыг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай байна. 2026 оны төсвийн төсөлд судалгаа, тооцоог бүрэн тусгаж ажиллалаа.	100
7.2.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Улсын болон ОНТөс өв, бусад дэмжлэг	Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	100	УБЕГазрын даргын 2024 оны А/180 тушаалаар батлагдсан Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу 2025 оны төсөв болон орон нутгийн хүний хөгжлийг дэмжих хөтөлбөртэй нийцүүлэн тус хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг 8 заалттай боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хэрэгжилттэй байна.	100
7.3	Байгууллагын ахмадын санг журмын дагуу хөтлөх,	Ахмадын сан	Ахмадын нийгмийн асуудлыг	2	1	Өмнөх оны төсвийн хэмнэлтээс 27,450.0 мянган төгрөгийг Ахмадын санд шилжүүлж, 2025 оны 11 сарын 1-ны өдрийн байдлаар байгууллагын 11	100

	зарцуулах		шийдвэрлэсэн тоо			ахмадад сар шинийн баяраар тус 227.3 мянган төгрөгийн гарын бэлэг, тэтгэвэрт гарсан С. Сарантуяад өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулж 5,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн дэмжлэг, ахмадын баяраар нийт 2,470.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл тус тус олгож 2025 оны 11 сарын 1-ны өдрийн байдлаар /нийт 3 удаа/ 9,970.0 мянган төгрөгийг зарцуулсан. Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба аяны хүрээнд “Ахмад-дунд-залуу” үеийн уулзалт өдөрлөг зохион байгуулж хэлтсийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэн	
7.4	Монгол бичгийн цахим бичвэрт албан хаагчдыг сургах	-	Цахим бичвэрээр бичих чадвартай болсон албан хаагчийн тоо	3	2	Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс □□”Үндэсний бичиг үсгийн баяр-2024”-ыг угтан зохион байгуулж буй арга хэмжээнд: 1. Мэдлэг сорих сорилд Г.Мөнхтуяа, Ц.Уртнасан, Г.Отгонмаа, Б.Оюунханд нар оролцсон. 2. Цахим бичвэрийн уралдаанд хэлтсийн дарга хамрагдсан. Хэлтсийн албан хаагчид үндэсний бичигт цахимаар түвшин ахиулан суралцаж байна. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгаж дүгнэн ажиллаж байна. Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформд байршуулсан цахим монгол бичгийн хичээлийг бие даан судлан хэлтсийн нийт 24 албан хаагч цахим бичвэрт суралцан сертификат авсан байна. ERP системийг тогтмол ашиглан албан бичиг солилцож байгаа 12 албан хаагч байна. Хэлтсийн өрөө тасалгаа 8, мэдээллийн самбар 2ш , танилцуулга, хувийн хэрэг 24 ш зар мэдээллийн брошур 3ш-ийг үндэсний бичгээр боловсруулан ажиллаж байна.	80

7.5	“Нэг албан хаагч-Нэг санаачилга” арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгууллага, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Санаачилж хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	10	15	Албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Нэг албан хаагч-Нэг санаачилга” арга хэмжээг тусгаж 20 арга хэмжээг санаачлан байгууллага хамт олны дунд хэрэгжүүлэн ажилласан байна. Амьдралын босго-16 нас, Гадаад паспортын өдөрлөг, алслагдсан Буянт багт болон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын ажлын байранд болон “Мандал” худалдааны төвийн 1 давхарт байрлан хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдэд хөдөлгөөнт 4 жи ашиглан үйлчилгээ үзүүлж, цахим гарын авлага тараан мэдээлэл хүргэн, сэтгэл ханамжийг үнэлүүлэн хийсэн цахим контент, Төрийн албан хаагчийн ёс зүй, Шударга ёс шуурхай үйлчилгээнээс эхэлнэ, Бурмаар тэтгэхээр урмаар тэтгэ, Эртэч шувуухай, “happy family day”, Санхүүгийн сахилга бат, 5С зарчим, Хөөс ажиллагаа, нөлөөллийн үйл ажиллагаа, ажлын байрны сүлжээний төхөөрөмжийн эмх цэгц, Бүртгэл төгөл, Амьдрах орчноо сайжруулах зорилтын хүрээнд их цэвэрлэгээ болон хөрөнгө оруулалтыг орон нутгаас шийдвэрлүүлэх зэрэг төсөвт ачаалал өгөхөөргүй үйл ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлж ажиллалаа. Тухай бүр мэдээллийг цахим мэдээллийн хаягаар хүргэж ажилласан.	100
7.6	Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 96-р тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	-	Крилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	100	100	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу А, Б 34 тушаалыг үндэсний бичгээр хөрвүүлэн ажилласан. Албан хаагчдад үндэсний бичгээр хөрвүүлэх заавар бичлэг хэлтсийн группэд байршуулсан мөн ERP системийн файлын санд үндэсний бичгээр шивэх бэлэн загвар байршуулж ажилласан. Явсан 537 бичгээс 330 бичгийг цахим монгол бичгээр хөрвүүлэн илгээж, 207 бичгийг хөрвүүлэн цахимд хадгалж байна. Тус хэлтсийн 13 албан хаагч цахим бичвэрт суралцаж хэрэгжүүлж байна.	100

7.7	Хууль зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугар тушаалаар батлагдсан “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үзлэг оношлогоонд албан хаагчдыг хамруулсан хувь	70	0	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2/6242 албан бичгийн хүрээнд Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар “Хамгийн чухал нь” эрүүл мэнд зорилтот арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 24 албан хаагч хамрагдахаас 21 албан хаагч, 9 гэр бүлийн гишүүд 8-н төрлийн үзлэг шинжилгээнд 100 хувь хамрагдсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд Нийт албан хаагч 100 хувь хамрагдсан байна. Эрүүл мэндийн үзлэгт 4400,0 төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.	100
-----	--	---	--	----	---	---	-----

Хэрэгжилт үнэлсэн:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА / Д.ДАВААНЯМ /
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА / Э.ГАНБАТ /
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)

Тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ/
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)